stabilizers have a strong element of social protection.¹¹ Further developing automatic stabilizers in Mongolia would complement existing fiscal rules and help mitigate the risk and uncertainty households face, and thus encourage private consumption.

¹¹ ADB. 2010. The Role of Fiscal Policy in Rebalancing the People's Republic of China. *ADB Briefs*.

I. Удиртгал

1. Төсвийн орлого зарлагыг удирдах нь аливаа засгийн газрын нэн тэргүүний үүрэг байдаг. Засгийн газар улсын төсөвт төвлөрч буй орлогын урсгалын хяналтын тогтолцоо, дүрэм журмуудыг тодорхойлж, төсвийн орлогыг хэрхэн хуваарилах талаар шийдвэр гаргах үүрэгтэй. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгаас эх үүсвэртэй орлогын хувьд тодорхой хязгаартай, аль нэг байршилд уягдсан, их хэмжээний огцом ашиг бий болгохын зэрэгцээ тухайн улсын эдийн засагтай харьцуулахад хэмжээний хувьд үлэмж бөгөөд тогтворгүй байдгаараа онцлогтой. Ийм нөхцөлд байгалийн баялгаас хэт хамааралтай төсвийн орлогыг зөв зүйтэй удирдаагүй тохиолдолд тухайн эдийн засаг мөчлөг дагасан савлагаа, авилгал, “Голланд өвчин”-д¹ нэрвэгдэх хор уршигтай юм.
2. Монгол Улсын уул уурхай, ашигт малтмалын салбар 2000 оны эхэн үеэс эхлэн хурдацтай өсөн тэлсэн. Тус салбар өдгөө эдийн засгийг давамгайлж, экспортын 90 хувийг бүрдүүлж байна. Монгол Улс эрдэс баялгийн бүрэн шавхагдаагүй асар их нөөцтэй бөгөөд дэлхийн судлагдсан нийт нүүрсний нөөцийн 10 хувь, дэлхийд хэмжээгээрээ дөрөвт бичигдэх зэсийн нөөц болон бусад олон төрлийн эрдэс баялгийн нөөц тус улсад байна. Монгол Улсын хувьд төсвийн нийт орлогынхоо 24 хувийг ашигт малтмал, уул уурхайн салбарын татварын болон татварын бус орлогоос бүрдүүлж байна. Мөн орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татваруудыг тус салбараас төвлөрүүлж байна.² Монгол Улсын Засгийн газар эрдэс баялгийн хэт хамаарлаас улбаатай сорилтуудыг даван туулахын тулд тодорхой бодлогуудыг хэрэгжүүлсээр ирсэн ба үүнд эрдэс баялгийн орлогыг удирдах санхүүгийн тусгай горим ба төсвөөс гадуурх сан зэргийг дурдаж болно. Гэхдээ бодлогын хэрэгжилт сул байснаас төсвийн алдагдал, өрийн ачаалал нэмэгдсээр иржээ. Эрдэс баялгийн орлогын төвлөрүүлэлтийг хэд хэдэн төрийн байгууллага хариуцаж, орлогын урсгалуудыг төвийн болон орон нутгийн захиргааны түвшинд хэт олон байгууллага татан төвлөрүүлж байгаа нь татвар хураах үйл ажиллагааг төвөгтэй болгож, үр дүнг нь сулруулж байна.
3. Эдгээр хүндрэл бэрхшээлийг авч үзвэл, Монгол Улсын байгалийн баялгийн орлогын менежментийг сайжруулах нь ирээдүйн хүртээмжтэй өсөлтийг хангахад амин чухал болоод байна. Монгол Улс үлэмж хэмжээний эрдэс баялгаа үр дүнтэй удирдахад нь дэмжлэг болох, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан зөвлөмжүүдийг энэхүү бодлогын тайлбар бичигт толилууллаа.

¹ Голланд өвчин гэдэг нь эдийн засаг их хэмжээний дотоод зарлага гаргаснаас үүдэн худалдаалах боломжтой нөөцөөс худалдаалах боломжгүй нөөц рүү шилжих үед төрдөг ойлголт юм. Энэ нь валютын ханшийг өсгөснөөр экспортын өрсөлдөх чадварыг бууруулдаг.

² Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам. 2018 он. *2019 оны улсын төсвийн төсөл*. Улаанбаатар хот.

II. Эрдэс баялгийн орлогын менежмент ба бодлогын сорилтууд

4. Мөчлөг дагасан савлагаанаас эдийн засагт үзүүлж буй нөлөөг саармагжуулах үүднээс шийдвэр гаргагчид 2010 оноос хойш олон төрлийн санаачлагуудыг авч хэрэгжүүлж эхэлсэн. Гэвч төсвийн бодлого, дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй, төсвийн сахилга бат муу байснаас зорьсон үр дүнд хүрээгүй юм. Энэ нь улмаар төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, өнөөгийн өрийн их дарамт, зогсолтгүй давтагдах эдийн засгийн бууралтын суурийг тавьсан.

5. **Төсвийн дүрэм журмууд сул хэрэгжиж байна.** 2010 оны 6 дугаар сард батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн (ТТБХ)³ хүрээнд Төсвийн тогтворжуулалтын сан (ТТС) байгуулагдсан. Орлого өндөртэй жилүүдэд илүү ихийг хуримтлуулж, эдийн засаг доройтох үед төсвийн зарлагын дарамтыг хөнгөвчлөх замаар төсвийн зарцуулалтыг оновчтой болгох, урьдчилан сэргийлэх хуримтлалын эх үүсвэр бий болгох зорилгоор энэхүү санг байгуулсан. Хуулийн хүрээнд төсвийн алдагдал болон Засгийн газрын өрийн өнөөгийн цэвэр үнэ цэнийн дээд хязгаарыг тогтоосон төсвийн тодорхой дүрмүүдийг зүйлчилсэн байдаг. Гэсэн хэдий ч эдийн засгийн хүндрэл бэрхшээлийн улмаас төсвийн алдагдал ихсэн, өр нэмэгдсэн тул тогтоосон дүрэм журмуудаа удаа дараа залруулж, шаардлагыг нь зөөллөсөн. Тухайлбал, батлагдсанаас нь хойш ТТБХ-д нийт 12 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Түүнчлэн, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Засгийн газраас санаачлан оруулсан 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр ТТС-ийн эх үүсвэрийг төсвийн алдагдал нөхөхөд зарцуулахыг зөвшөөрсөн. Эхэндээ ганц удаагийн зохицуулалт хэмээн төлөвлөж байсан энэхүү нэмэлт өөрчлөлтийн хугацааг 2017 онд сунгаж, ТТС-гийн бүх хуримтлагдсан хөрөнгийг 2023 он хүртэл төсвийн цоорхой нөхөх зорилгоор зарцуулж болохоор зохицуулжээ.⁴

6. **Үндэсний баялгийн сан олшрох төлөвтэй байна.** 2016 онд Ирээдүйн өв сангийн (ИӨС) тухай хуулийг баталж, орлогын эх үүсвэрийн талаарх хоёрдахь дүрмийг тодорхойлов.⁵ Хуульд зааснаар, хойч үедээ зориулж уул уурхайн орлого болон нөөц ашиглалтын төлбөрийн тодорхой хувийг шинээр байгуулагдсан үндэсний баялгийн сан болох ИӨС-д төвлөрүүлэх юм. Энэ нь Хүний хөгжлийн сангийн⁶ өр 2019 онд төлөгдөж дууссаны дараа эхлэхээр төлөвлөгдсөн. Сангийн хөрөнгийг 2030 он хүртэл хуримтлуулах ба үүнээс хойш ИӨС-гийн хуримтлалаар хийсэн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг жил бүр

³ Монгол Улсын Засгийн газар. 2010 он. *Төсвийн тогтвортой байдлын тухай хууль*. Улаанбаатар хот.

⁴ Монгол Улсын Засгийн газар. 2016 он. *Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт орсон 9(1).3.4 дэх заалт*. Улаанбаатар хот; Монгол Улсын Засгийн газар. 2017 он. *Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт орсон 34.2 дахь заалт*. Улаанбаатар хот.

⁵ Монгол Улсын Засгийн газар. 2016 он. *Ирээдүйн өв сангийн тухай хууль*. Улаанбаатар хот.

⁶ Хүний хөгжлийн санг иргэн бүрт мөнгөн тэтгэмж тараах зорилгоор анх 2009 онд байгуулсан ба санхүүжилтийн эх үүсвэр нь хомс болсноос тус санд ихээхэн өр хуримтлагдсан.

захиран зарцуулахаар заасан байдаг. ИӨС-г сайн засаглалын зарчмуудын дагуу байгуулж, итгэл хүлээх хариуцлага, хөндлөнгийн хяналт, мэргэжлийн удирдлага, Голланд өвчний хор уршгийг бууруулах зорилгоор хөрөнгийн тодорхой хэсгийг олон улсын хөрөнгийн зах зээлд гаргах зэрэг зарчмуудыг баримтлахаар хуульчилсан. ИӨС байгуулагдсанаас хойш дахин хэд хэдэн үндэсний баялгийн санг байгуулах санаачлага мөн гарч байжээ. Олон сан шинээр байгуулах нь орлогын удирдлагыг төвлөрсөн бус болгож, засаглал болон хөрөнгийн хяналтыг хүндрүүлэх уршигтай юм.

7. **Төсвийн сахилга бат сул байна.** Төсвөөс гадуурх болон төрийн өмчит байгууллагуудын зардал нэмэгдсэн нь төсвийн холбогдолтой дүрэм, журмын сул хэрэгжилтийн үр дагаврыг улам даамжруулсан. Үүнд Засгийн газрын баталгаатай зээлийн эх үүсвэрийг төслийн санхүүжилтэд зарцуулсан Монгол Улсын Хөгжлийн банк болон үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн Монголбанк зэргийг дурдаж болно. 2016 оны парламентын сонгуулийн дараагаар байгуулагдсан Засгийн газар эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээнүүдийнхээ хүрээнд төсвөөс гадуурх болон төрийн өмчит байгууллагуудын зарцуулалтыг хумьсан. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулинд өөрчлөлт оруулж, үйл ажиллагаа болон санхүүгийн бие даасан байдлыг нь бэхжүүлсэн бөгөөд Монголбанкнаас хэрэгжүүлж байсан үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдийг зогсоосон. 2017 оноос эхлэн төсвийн сахилга бат үлэмж сайжирснаар Монгол Улсын Засгийн газрын өрийн ачаалал хөнгөрч, төв банкны өрийг багтаасан улсын нийт өр хоёр хүрэхгүй жилийн дотор 25 нэгж хувиар буурчээ. Гэсэн хэдий ч, эдийн засгийн энэхүү сэргэлт нь гадаад цочрол, нэн ялангуяа түүхий эдийн үнийн уналтын нөлөөлөлд эмзэг хэвээр байна.

8. **Эдийн засгийн уналт давтагдсаар байна.** Бодлогын алдаа дутагдлын улмаас улсын төсвийн зарлага эрдэс баялагийн түүхий эдийн үнийн өөрчлөлтийг дагаж савласаар байна. Орлогын төвлөрүүлэлт тогтвортой бус нөхцөлд хэт үрэлгэн төсөв баталж, хэрэгжилт нь доголдолтой томоохон дэд бүтцийн төслүүдийг эхлүүлсэн нь түүхий эдийн үнэ унах үед засгийн газрын өрийг үлэмж хэмжээгээр өсөхөд хүргэсэн. Өрийн дарамт их байгаагаас нийгмийн суурь үйлчилгээг санхүүжүүлэх төсвийн эх үүсвэр эдийн засгийн уналтын буюу хамгийн хэрэгцээтэй үед их хэмжээгээр багасч байна. Орлогын дахин хуваарилалтын бодлого оновчгүй, тогтворжуулагч механизм байхгүй зэргээс Монгол Улсын эдийн засаг дахин дахин уналтад орж, нийгмийн тогтвортой байдалд аюул занал учирч, гадаадын хөрөнгө оруулагчид буцаж байна.

III. Олон улсын туршлага

9. Дэлхийн улс орнууд төсвийн зарцуулалт, хуримтлал, зээл, орлогын төвлөрүүлэлт болон санхүүгийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэхдээ макро эдийн засгийн хүрээг ашигладаг. Орлогын хэлбэлзэл болон үрэлгэн зарцуулалт түгээмэл тохиодог, байгалийн баялгаас хамааралтай улс орнуудын хувьд улсын төсвийг удирдахад ихээхэн бэрхшээл тулгардаг. Иймд, байгалийн баялагт түшиглэсэн улс оронд хэрэгжүүлэх макро эдийн засгийн хүрээ

Improving Management of Natural Resource Revenues in Mongolia

—Монгол Улсын эрдэс баялгийн орлогын менежментийг сайжруулах нь

нь зарлагыг тогтворжуулах болон нийт төсвийн тогтвортой байдлыг хангах зорилтуудаа тэнцвэртэйгээр хослуулж, эдийн засгийн мөчлөгийн улмаас хүн амд үзүүлэх нийгэм-эдийн засгийн сөрөг нөлөөллөөс хамгаалах механизмуудыг бэхжүүлэх хэрэгтэй.

10. Чили, Норвеги, Перу, Катар болон Саудын Араб зэрэг улсад байдаг шиг Зарлагыг тогтворжуулах арга нь төсвийн зарцуулалтын савлагааг хянах зорилгоор төсвийн орлого зарлагыг хооронд нь заагладаг. Эдгээр улс орны засгийн газрууд төсвийн орлого жилээс жилд хэрхэн өсөх эсвэл буурахаас үл хамааран жил бүрийн төсвийн зарцуулалтыг аажмаар нэмэгдүүлэх зарчмыг баримталсан. Үүний тулд эрдэс баялгийн салбараас олсон ашгийг өрийн ачааллыг бууруулахад хэрэглэх эсвэл үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд зарцуулах зэрэг аргачлалыг ашигласан байна. Үйл ажиллагаа нь амжилттай яваа үндэсний баялгийн сангуудын сургамжаас харахад улс орнууд хуримтлал үүсгэх цаг мөчийг зөв сонгох улс төр-эдийн засгийн шийдвэрээ (учир нь төсвийн орлого их байх үед хуримтлал үүсгэх сонирхол харьцангуй сул байдаг) өрийн ачаалал бууруулах хүчин чармайлттай тэнцвэртэйгээр хослуулсан байна.

11. Ихэнх үндэсний баялгийн сан нь төсвийн ашгаас санхүүжигдэх бөгөөд (тухайлбал, Чили, Казахстан, Норвеги, Катар, Саудын Араб, Зүүн Тимор гэх мэт), засгийн газрын өр багатай, өрийн хэмжээ буурч буй орнуудад байгуулагдсан байдаг (тухайлбал, Ботсвана, Оросын Холбооны Улс). Нөхцөл нь бүрдээгүй үед, эсвэл байгалийн баялгийн орлого бага буюу тодорхой бус, төсвийн алдагдал их, өрийн ачаалал өндөртэй үед байгуулагдсан үндэсний баялгийн сангуудын хувьд хөрөнгө оруулалтын өгөөж нь зээлийн хүүний хэмжээнээс бага байвал дампуурах нь түгээмэл. Аргентин, Гана, Венесуэл зэрэг улсуудад төсвөө санхүүжүүлэх, засгийн газрын өрөө эргэн төлөх зорилгоор төсвийн дүрмээ зөрчин хуримтлалаасаа зарцуулсан байдаг. Тухайлбал, Аргентины төрийн тэтгэврийн сангаас 2013-2014 онд засгийн газартаа 14 гаруй тэрбум ам.долларын бага хүүтэй зээл өгсөн. Гана Улсын хувьд засгийн газар нь газрын тосны орлогоос санхүүждэг Тогтворжуулалтын сангийн хөрөнгөд дээд хязгаар тавих замаар хуримтлалаа хоосолсон. Харин Венесуэлд газрын тосны жишиг үнийг⁷ өөрчлөн, сангаас захиран зарцуулах ерөнхийлөгчийн бүрэн эрхийг өргөжүүлсний уршгаар Макро эдийн засгийг тогтворжуулах хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг дуусгасан байна.⁸

12. Зарлагыг тогтворжуулж, төсвийн тогтвортой байдлыг хангах үр дүнтэй хэрэгсэл бол төсвийн цогц дүрэм мөн болохыг олон улсад амжилттай хэрэгжсэн туршлагаас харж болно. Төсвийн дүрмийн олон төрөл байдаг ч мөчлөг сөрсөн, хязгаарлалтаас чөлөөлөх

⁷ Хэрэв газрын тосны үнэ жишиг үнээс давбал олсон орлогын зарим хэсгийг хуримтлал үүсгэн хадгална. Газрын тосны үнэ жишиг үнээс доогуур байх үед хуримтлалаас авч ашиглаж болно.

⁸ Монголиан Майнинг Журнал. 2015 он. Санал болгоод буй Ирээдүйн өв сангийн тухай хоёр бодрол. 11 дүгээр сарын 9. <http://www.mongolianminingjournal.com/a/61366>

нөхцөлүүдийг тодорхой тусгасан, ойлгох, хянах, хэрэгжүүлэхэд хялбар дүрмүүдийн хэрэгжилт хамгийн сайн байдаг. Зарлагын дүрэм бол ийм дүрмийн жишээ юм. Тухайлбал, Перу Улсад төсвийн бодит урсгал зардлыг жилд хамгийн ихдээ 4 хувиар өсгөхийг зөвшөөрдөг. Гэхдээ Конгресс онцгой байдал зарласан тохиолдолд үүнийг өөрчилж болдог байна. Үүнтэй ижлээр Гренада Улсын журамд төв засгийн газар болон төрийн өмчит байгууллагуудын төсвийн бодит урсгал зардлын өсөлтийг жилийн 2 хувиар хязгаарласан. Харин Парагвай Улсад үндсэн зарцуулалтын өсөлтийн дээд хязгаарыг жилийн 4 хувиар тогтоосон байдаг. Дээрх гурван улс орны аль алинд нь зарлагын дүрмийн зэрэгцээ тэнцлийг хангах төсвийн дүрмийг даган мөрддөг. Тухайлбал, Парагвайд төсвийн нийт алдагдал Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 1.5 хувиас хэтэрч болохгүй, гэхдээ үндэсний онцгой байдал зарласан эсвэл эдийн засгийн хямрал тохиосон нөхцөлд 3 хувьд хүрэхийг зөвшөөрнө. Төсвийн дүрэм бодитой хэрэгжихэд тухайн орны улс төрийн томоохон намууд зөвшилцөлд хүрсэн байх шаардлагатайг Бразил, Чили, Колумб, Норвегийн жишээ батлан харуулсан.

IV. Зөвлөмж

13. Монгол Улсын газар зүйн байрлал, хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдлыг харгалзаж үзвэл тогтвортой хөгжлийг цогцлоохын тулд төрөөс томоохон хөрөнгө оруулалтуудыг (голчлон дэд бүтцэд) хийх шаардлагатай бөгөөд үүнийг эрдэс баялгийн орлогоор санхүүжүүлэх боломжтой. Ийм хөрөнгө оруулалт хийхдээ өрийн ачааллыг хэт нэмэгдүүлж, улмаар эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, шинэ ажлын байрны боломжийг хазаарлан, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахаас сэргийлэхийн тулд байгалийн баялгийн орлогын менежментийг сайжруулах нь нэн чухал. Монгол Улсын өөрийн туршлагыг олон улсын шилдэг практиктай хослуулан зөв, үр дүнтэй бодлого боловсруулах боломжтой. Бодлогын суурь бүрэлдэхүүн хэсгүүд нэгэнт бий болсон учир төсвийн дүрмийг тууштай хэрэгжүүлэн, төсвийн сахилга батыг бэхжүүлэх замаар төсвийн орлогын удирдлагыг бэхжүүлэхэд чиглэсэн ойрын болон урт хугацааны дараах зөвлөмжүүдийг санал болгож байна.

а. Ойрын хугацаанд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

14. **Төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх.** Төрийн бүх зарлагыг улсын төсөвт нэгтгэж, орлогын удирдлагын төвөгтэй тогтолцоог хялбаршуулах нь төсвийн зарцуулалтыг оновчтой болгож, хяналтыг сайжруулахад дэмжлэг болно. Үүнийг хэрэгжүүлэх нэг арга зам нь төсвөөс гадуурх төрийн байгууллагын тоог цөөлж, зөвхөн төрийн санхүүгийн удирдлагын ил тод байдлыг хангах, иргэдийн итгэлийг бэхжүүлэхэд хэрэгтэй хэсгийг авч үлдэх явдал юм. Мэдээллийг хангалттай хэмжээнд нийтэд түгээх нь чухал ач холбогдолтой. Төсвийн баримт бичиг нийтэд нээлттэй байж, Монгол Улсын Үндэсний аудитын газраас шаардлагатай хяналтыг тавьж байгаа хэдий ч төсөв төлөвлөлтийн явцад орон нутгаас бусад түвшинд олон

Improving Management of Natural Resource Revenues in Mongolia

—Монгол Улсын эрдэс баялгийн орлогын менежментийг сайжруулах нь

нийтийн оролцоо дутмаг байгаа бөгөөд жилийн эцсийн тайлангууд нийтлэгдэхгүй байна. Засгийн газрын зүгээс төсвийн гүйцэтгэлийн талаар иргэдэд илүү дэлгэрэнгүй мэдээлж, улсын төсөв төлөвлөлтийн талаар олон нийтийн форум хэлэлцүүлгүүд зохион байгуулж болох юм. ТТС болон ИӨС-гийн талаарх мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлэлд оруулах шаардлагатай. Энэ ажлыг хийхэд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага гэх мэт байгууллагууд туслалцаа үзүүлэх боломжтой ба тус санаачлагын хүрээнд Монгол Улсын гаргасан анхан шатны ахиц дэвшил дээр тулгуурлан цаашид үргэлжлүүлэх нь чухал юм.⁹

15. Улсын төсвөөс гадуурх шинэ сан байгуулахаас зайлсхийх. ИӨС-гийн тухай хуулинд тухайн сангийн одоогийн хүчирхэг засаглалын зарчмуудыг өөрчилсөн нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх нь зүйтэй. Төсвөөс гадуурх шинэ сан байгуулахын оронд төрийн санхүүгийн менежментийг сайжруулахад анхаарвал зохино. Уул уурхайн салбараас төвлөрүүлсэн орлогоор төсвийн хөрөнгө оруулалтыг шууд санхүүжүүлдэг сан ажиллуулах нь хөрөнгө оруулалтын төслүүдийн чанар муу, хяналт сул байх суурийг тавьж, улмаар түүхий эдийн үнэ унах үед улс орныг санхүүгийн томоохон эрсдэлд оруулдаг. Засгийн газрын хувьд гадаад валютын активын урт хугацааны өгөөж гадаад өрийн хүүний төлбөрөөс өндөр байх үед валютын хуримтлалд анхаарах нь зүйтэй. Иймд, засгийн газрын өрийг даахуйц хэмжээнд багасгах нь нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх амин чухал алхам болно. Төсвийн орлогын тодорхой хувийг авч үлдэн ИӨС-ийн хөрөнгө, хуримтлалыг аажмаар нэмэгдүүлэх замаар өрийн ачааллыг бууруулах боломжтой. Цаашид өрийн багцын удирдлагыг оновчтой болгох зорилгоор Монгол Улсын эрдэс баялагт түшиглэн түүхий эдийн үнэтэй уягдсан бонд гэх мэт санхүүгийн хэрэгсэл ашиглаж болох юм.

16. Засгийн газрын төсвийн зарцуулалтыг үндэсний болон эрдэс баялгийн салбарын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах. Үндэсний хөгжлийн төлөвлөгөөнүүдэд төсөл бүрийн өртөг, хугацаа, санхүүжилтийн мэдээллийг тодорхой заах нь төсвийн зарлага үр дүнтэй байх урьдач нөхцөл юм. Харин төслийн түвшинд эдийн засгийн өсөлтөд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэж буй эсэх, эдийн засгийн кластерийн¹⁰ чухлыг тооцоолж буй эсэх, мөн хэрэгжүүлэхэд үр ашигтай эсэхийг нь тооцож үзсэний үндсэн дээр төслүүдийг эрэмбэлэх журам хэрэгжүүлбэл зохино. Ингэхдээ, иж бүрэн техник, эдийн засгийн үндэслэлийг төлөвлөлтийн эхний шатанд боловсруулахыг шаардсанаар шийдвэр гаргалтыг оновчтой болгож, төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг улс төрийн мөчлөгөөс тусгаарлах ач холбогдолтой.

⁹ Монгол Улс анх 2006 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагад нэгдэн орсон ба одоогоор тус санаачлагаас тавьдаг бүх шалгуурыг хангасан 6 орны нэг юм (нийт 51 орноос).

¹⁰ Газар зүйн нэг байршилд төвлөрсөн аж ахуйн нэгжүүдийн бүлэглэлийг эдийн засгийн кластер гэнэ.

17. **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг бэхжүүлэх.** Шинээр байгуулагдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь өөрчлөлт шинэчлэлд түлхэц өгөх боломжтой хэдий ч улс төрийн нөлөөлөл орж, бүрэн эрх нь хязгаарлагдмал байвал үр дүнд хүрэхгүй. Иймд, зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг баталгаажуулах, боловсон хүчин болон санхүүжилтээр хангах, улс төрөөс хараат бус эсвэл олон намын дэмжлэг авсан гишүүдээс бүрдүүлэх зэргээр зөвлөлийн бие даасан байдлыг бэхжүүлж болно. Мөн түүнчлэн, холбогдох бүхий л төрийн баримт бичигтэй хязгаарлалтгүйгээр танилцах бүрэн эрхийг Засгийн газраас зөвлөлд олгох нь зүйтэй. Зөвлөл нь төсвийн орлогын төлөвлөлтийг сайжруулах зорилгоор төсвийн бие даасан төсөөлөл боловсруулах үүрэг хүлээвэл зохино.

б. Дунд болон урт хугацааны бодлогын арга хэмжээ

18. **Төсвийн болон макро эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах.** ТТБХ-нд Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг хангах замын зураг болох төсвийн дүрмүүдийг тодорхойлсон. Өрийн дээд хязгаарын дүрэмд урт хугацаанд өрийн тогтвортой байдлыг хангах зорилтыг тодорхойлсон бөгөөд Монгол Улс өрийн зохицуулалт хийх эсвэл төсвийн ашгийн эх үүсвэрээр эргэн төлөх замаар 2017 оноос хойш өрийн ачааллаа бууруулах тал дээр гаргасан ахиц дэвшил дээрээ дөрөөлөн энэхүү зорилтод хүрэх боломжтой юм. Согтууруулах ундаа болон тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх, орлогын шатлалт татварыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийг өсгөх, төсвөөс гадуурх болон төрийн өмчит байгууллагуудын зардлуудыг зогсоох зэрэг арга хэмжээ нь энэхүү зорилтод хүрэхэд мөн чухал ач холбогдолтой. Төсвийн тэнцлийг хангах дүрэм болон зарлагын дүрэм нь өнгөрсөн үе шиг төсвийн алдагдал хуримтлагдахаас сэргийлэх боломжийг олгоно. Орлогын дүрмийн хүрээнд Монгол Улсын ТТС байгуулагдсан ба энэ нь орлого өндөртэй жилүүдэд хуримтлал үүсгэж, хүнд жилүүдийг даван туулах хамгаалалтыг бий болгох зорилготой. Төсвийн эдгээр дүрмийн зэрэгцээ мөнгөний болон санхүүгийн салбарын оновчтой бодлого хэрэгжүүлснээр макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах боломж бүрдэнэ. Засгийн газрын зүгээс одоогийн Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөр дуусгавар болох цаг үеийг Монгол Улсын ирээдүйн бодлогын орчинд макро эдийн засгийн оновчтой бодлогуудыг хэвшүүлэх боломж хэмээн харж, хэрэгжүүлэх нь чухал юм.

19. **Эдийн засгийг төрөлжүүлэх.** Эрдэс баялгийн хамаарал багатай, илүү төрөлжсөн эдийн засаг нь түүхий эдийн үнийн мөчлөг дагасан савлагаанд бага өртдөг. Ийм эдийн засаг нь хөрөнгө оруулалт их шаарддаг уул уурхайн салбарыг бодвол илүү хүртээмжтэй байж, Монголчуудад илүү олон эдийн засгийн боломжийг олгоно. Монгол Улсын хөдөө аж ахуй болон тогтвортой аялал жуулчлалын салбарууд нь эдийн засгийг төрөлжүүлэх өндөр боломжтой салбарууд юм. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэхэд тогтвортой макро эдийн засгийн бодлогууд шаардлагатай бөгөөд энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдыг татахын зэрэгцээ Монгол Улсын үндэсний валютын хөрвөх ханш өрсөлдөх чадвартай буюу экспортыг дэмжихүйц бодит үнэлгээтэй байх явдлыг хангана. Худалдааны оновчтой бодлого хэрэгжүүлж, Монголын бүтээгдэхүүнийг экспортлох боломжтой зах зээлийн тоог

нэмэгдүүлэх нь ихээхэн чухал. Харин дотооддоо санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, нэн ялангуяа хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнесүүдийг дэмжих нь зүйтэй юм. Түүнчлэн, Засгийн газрын зүгээс экспортыг дэмжихийн тулд хязгаарлагдмал санхүүгийн эх үүсвэрээсээ зам тээвэр, лабораторын үйлчилгээ гэх мэт төрийн үйлчилгээг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах зайлшгүй шаардлагатай байна. Эдийн засгийг төрөлжүүлэх нь цаг хугацаа шаардсан ажил бөгөөд Монгол Улс цаашид уул уурхайн өсөлт хөгжлийг хэрхэн нийтэд илүү хүртээмжтэй болгохыг судалбал зохино. Тухайлбал, тус салбарт ажиллаж эсвэл бараа үйлчилгээ нийлүүлж үр ашгаас нь хүртэх Монголчуудын тоог нэмэх зорилгоор боловсрол, мэргэжлийн сургалтанд хөрөнгө оруулж болох юм.

20. Орлогын хуваарилалтын бодлого болон тогтворжуулагч механизмуудыг сайжруулах. Өмнөх туршлагаас харахад орлогын хуваарилалтын бодлого байхгүй нөхцөлд эдийн засгийн хурдацтай өсөлт орлогын тэгш бус байдлыг бий болгодог буюу даамжруулдаг байна. Өндөр орлоготой ихэнх улс орнуудын хамгааллын тогтолцоо нь өндөр хөгжсөн байдаг бөгөөд улс орны хөгжлийн хэрэгцээтэй уялдан хувьсан өөрчлөгдөж байдаг. Орлогын ялгааг нөхөхөд шаардагдах нийгмийн хамгааллын нэмэгдэл зардлыг татвар төвлөрүүлэлтийг сайжруулах замаар санхүүжүүлж болно. Тухайлбал байж болох нэг аргачлал нь шууд татварын орлогын төвлөрүүлэлтэд голлон анхаарах явдал юм. Шууд бус татварын хувьд төсвийн орлогыг үр дүнтэйгээр нэмэгдүүлдэг хэдий ч орлого багатай болон ихтэй иргэдэд ижил ногддоогоороо ихээхэн сөрөг үр дагавартай. Татварын дарамт ачааллыг бага орлоготой өрхүүдээс өндөр орлоготой өрхүүд рүү шилжүүлэхийн тулд орлогын шатлалттай татварын тогтолцоо ашиглаж болно. Үүнээс гадна, “автомат тогтворжуулагч” механизм, бизнесийн мөчлөгтэй уялдан автоматаар тохиргоо хийгддэг татвар болон тэтгэмжийн тогтолцоо нэвтрүүлэх хэрэгтэй ба эдийн засгийн бууралтын үед нийгмийн халамжийн зардал ихсэж, өсөлтийн үед буурах зохицуулалт бүхий зарлагын дүрэм эсвэл татварын багц хуулиар үүнийг хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал, ажилгүйдэл нэмэгдсэнээс үүдэлтэй эдийн засгийн уналтын үед ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулагдах төсвийн зарлага шууд ихсэх хандлагатай байдаг. Богино хугацаанд бүтээмжийн хэлбэлзлийг бууруулах үндсэн зорилготой “автомат тогтворжуулагч” механизмууд нь нийгмийн хамгааллын хүчирхэг хэрэгсэл болдог.¹¹ Иймд, цаашид Монгол Улсад “автомат тогтворжуулагч” тогтолцоог нэвтрүүлснээр одоогийн төсвийн дүрмүүдийн хэрэгжилтэд дэмжлэг болж, айл өрхүүдэд тулгарч байгаа эдийн засгийн эрсдэл болон тодорхой бус байдлыг бууруулан, улмаар дотоодын хэрэглээг хөхиүлэн дэмжинэ.

¹¹ АХБ. 2010 он. БНХАУ-ын тэнцвэртэй байдлыг эргэн тогтооход төсвийн бодлогын гүйцэтгэсэн үүрэг. АХБ-ны товч хэвлэл.

Improving Management of Natural Resource Revenues in Mongolia

Mongolia's economic fortunes are closely tied to the performance of its major commodities, especially those in the mineral sector. As a result of commodity dependence, the economy is exposed to boom and bust cycles. This policy note draws on the experience of other countries to offer solutions to help Mongolia achieve sustained macroeconomic stability by improving the management of its natural resource revenues. The recommendations focus on strengthening public financial management and policy implementation as well as the need to foster economic diversification.

Монгол Улсын эрдэс баялгийн орлогын менежментийг сайжруулах нь

Монгол Улсын эдийн засаг экспортын үндсэн түүхий эдийн гүйцэтгэлээс, тэр дундаа эрдэс баялгийн салбараас ихээхэн хамааралтай. Энэ нь эдийн засгийг түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамааралтай мөчлөг дагасан савлагаанд өртөмтгий болгодог. Олон улсын туршлага дээр үндэслэн эрдэс баялгийн орлогын менежментийг сайжруулах замаар Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах шийдлүүдийг энэхүү бодлогын тайлбар бичигт багтаасан. Санал болгож буй зөвлөмжүүд нь төрийн санхүүгийн менежментийг бэхжүүлэх, бодлогын хэрэгжилтийг сайжруулах, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих зэрэгт чиглэв.

About the Asian Development Bank

ADB is committed to achieving a prosperous, inclusive, resilient, and sustainable Asia and the Pacific, while sustaining its efforts to eradicate extreme poverty. Established in 1966, it is owned by 68 members—49 from the region. Its main instruments for helping its developing member countries are policy dialogue, loans, equity investments, guarantees, grants, and technical assistance.

Азийн хөгжлийн банкны тухай

АХБ нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ цэцэглэн хөгжсөн, хүртээмжтэй, тогтвортой, сөрөг нөлөөнд тэсвэртэй бүс нутгийг цогцлоохын төлөө тууштай ажилладаг. Анх 1966 онд байгуулагдсан тус банкны нийт 68 гишүүн орны 49 нь тухайн бүс нутагт оршдог. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, өөрийн хөрөнгийн санхүүжилт, батлан даалт, буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлж байна.



ASIAN DEVELOPMENT BANK

6 ADB Avenue, Mandaluyong City
1550 Metro Manila, Philippines
www.adb.org

Азийн хөгжлийн банк

АХБ-ны өргөн чөлөө-6, Мандалуён хот
Метро Манила 1550, Филиппин Улс
www.adb.org